



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГТ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ
ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-ГА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Аудитор Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 цахим хуудас: bunchinsurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2024 он



Агуулга

1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх.....	3
БҮЛЭГ 1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх.....	5
1.1.1 Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.....	5
1.1.2 Сонгуулийн хороо болон хэсгийн хороодод улсын төсвөөс сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.....	5
1.1.3 Аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс Монгол улсын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.....	7
БҮЛЭГ 1.2 УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?.....	8
1.2.1. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны а/17 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг зарим сумын сонгуулийн хороод нь мөрдөж ажиллаагүй байна.....	8
1.2.2. Гурван сумын сонгуулийн хороо зардлын тайланг зөрүүтэй 2,701.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.....	9
1.2.3. Аймгийн Сонгуулийн хорооноос зарим сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.....	10
ДҮГНЭЛТ:	11
ХАВСРАЛТУУД:	12



Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МТ	Мэдээлэл технологи
МТБ	Мэдээлэл технологийн баг
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МҮЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д аудит хийв.

Аудитын зорилт

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв.Үүнд:

1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?
2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт олгосон сонгууль зохион байгуулахтай холбогдон зардлыг хамруулан шалгав.

Аудитын хязгаарлалт

Аймгийн сонгуулийн хороо болон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймаг дахь Цагдаагийн газарт батлагдсаны дагуу хуваарилагдаж ирсэн зардлаас бусад зардал хамаарахгүй.

Аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 08-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮЛЭГ 1.1 УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?

Баянхонгор аймагт УИХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлыг урьдчилан тооцоолохдоо шаардлагатай мэдээллийг гаргуулан авч СЕХ төсвийг тооцож удирдамж гарган хуваарилсан бөгөөд аймгийн сонгуулийн хороо нь удирдамжийн дагуу сонгуулийн хорооддоо хуваарилсан байна.

1.1.1 Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Баянхонгор аймагт 2024 оны Улсын их хурлын /цаашид УИХ гэх/ сонгуулийг зохион байгуулах улсын төсвөөс гарах зардлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо тэдгээрийн байршил хоорондох зай зэрэг шаардлагатай мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд /цаашид СЕХ гэх/ хүргүүлсний үндсэн дээр сонгууль зохион байгуулах зардлын төсөв хуваарилагдаж ирж байна.

Хэрэгцээ шаардлагыг дээрх байдлаар тодорхойлж байгаа нь хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардлыг тооцоолох гол үзүүлэлт болж байгаа бөгөөд харин бичиг хэрэг, сургалт сурталчилгаа, шуудан холбооны зардлыг тогтмол байхаар тооцож ирүүлсэн байна.

1.1.2 Сонгуулийн хороо болон хэсгийн хороодод улсын төсвөөс сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд 5 удаагийн удирдамжийн дагуу нийт 1,088,397.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Санхүүжилтийг /Хавсралт АБ №01/хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан зардал /мянган төгрөг/

№	Зардлын нэр	СЕХ-ны 2024.04.16-ны өдрийн 3/229	СЕХ-ны 2024.05.02-ны өдрийн 3/290	СЕХ-ны 2024.05.21-ны өдрийн 3/373	СЕХ-ны 2024.06.09-ны өдрийн 3/472	СЕХ-ны 2020.06.18-ны өдрийн 3/562	Нийт
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0					300.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	11,681.0					11,681.0
3	МТБ, даамлын сургалт		23,940.0				23,940.0
4	Бичиг хэрэг		16,480.0				16,480.0
5	Шуудан холбоо		19,600.0				19,600.0
6	Унаа		85,050.0				85,050.0
7	Санал авах байр бэлтгэх			32,240.0			32,240.0
8	Сурталчилгаа			8,000.0			8,000.0
9	Саналын хуудсыг хүргэх ачаа, томилолтын зардал				52,628.0		52,628.0
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал				1,300.0		1,300.0
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ					669,592.0	669,592.0
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ					80,696.0	80,696.0
13	Хоолны зардал					60,900.0	60,900.0



14	Томилолтын зардал					13,876.0	13,876.0
15	Шуурхай багийн зардал					4,409.0	4,409.0
16	Болзошгүй зардал					7,705.0	7,705.0
НИЙТ ДҮН		11,981.0	145,070.0	40,240.0	53,928.0	837,178.0	1,088,397.0

Эх сурвалж: СЕХ-ны Тамгын газрын албан тоотууд

Дээрх зардлаас сумдын сонгуулийн болон хэсгийн хороодод нийт 1,007,362.0 мянган төгрөгийн зардлыг хуваарилснаас 992,410.0 мянган төгрөгийг сумдын сонгуулийн хорооны данс руу шилжүүлсэн байна. Харин сонгуулийн хорооны гишүүдийн хоолны зардал 3,040.0 мянга, мэдээлэл технологийн даамлын сургалтын хоолны зардал 7,302.0 мянга, 104 хэсгийн хорооны төрийн далбааны 4,610.0 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны данснаас нэгдсэн байдлаар шилжүүлэг хийсэн байна. /Хавсралт АБ №01/

Хүснэгт № 2. Сумдын сонгуулийн хороонд хуваарилсан зардал /мянган төгрөг/

№	Зардлын төрөл	Нийт зардал	Үүнээс:		Тайлбар
			Сумдад хуваарилсан	АСХ зохион байгуулсан	
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.00		300.00	Сонгуулийн хорооны маягт хэвлэх зардлыг аймаг бүрд 300.0 мянган төгрөгөөр хувиарласан.
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	11,681.00	6,380.00	5,301.00	Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, нягтлан бодогч, МТБ-ийн ахлагч нарын УБ хотод хийх томилолтыг нэг өдрөөр хоолны зардлыг 3 өдрөөр 1,200,000₮ ((1өдөр*150,000+3өдөр*50000₮)*4хүн) сумдад томилолт 4,940,000₮ (1 сум *2 хүн*1 өдөр *130,000₮) Унааны зардал 1,440,000₮ сум руу ирж очих дундаж тарифаар, Хоолны зардал 3,040,000₮-ийг нэгдсэн журмаар хоолонд оруулахаар зохицуулж аймгийн сонгуулийн хороонд хувиарласан. Сургалтын зардлыг 25,000 төгрөгөөр тооцсон байна.
3	МТБ даамлын сургалт	23,940.00	16,638.00	7,302.00	Сумдад унааны зардал дундаж тарифаар 2,988,000₮, Сумдын даамлын томилолт 13,650,000₮(105 хүн*130,000₮), Хоолны зардал 7,302,000₮ нэгдсэн журмаар хоолонд оруулахаар зохицуулж аймгийн сонгуулийн хороонд хувиарласан байна.
4	Бичиг хэргийн зардал	16,480.00	15,480.00	1,000.00	Аймгийн сонгуулийн хороонд 1 сая төгрөг, Сум бүрт 150,000₮, хэсэг тус бүрт 120,000₮
5	Шуудан холбооны зардал	19,600.00	18,600.00	1,000.00	Аймгийн сонгуулийн хороонд 1 сая төгрөг, Сум, хэсэг тус бүрт 150,000₮
6	Унааны зардал	85,050.00	81,600.00	3,450.00	Унааны зардлыг аймгийн сонгуулийн хороонд 2,450,000₮ (3500км*700₮) Сумдад 1 сумд 700км 700₮-өөр нэг хэсгийн унааны зардлыг 6000км-ийг 700₮ өөр тооцсон байна.
7	Сурталчилгаа	8,000.00	2,100.00	5,900.00	Аймгийн сонгуулийн хороонд 5,900,000₮, сум тус бүрт 100,000₮-өөр хувиарласан байна
8	Санал авах байр бэлтгэх зардал	32,240.00	28,080.00	4,160.00	Нэг хэсгийн хороонд 310 мянга нийт 104 хэсгийн хороонд 23100,0 мянган төгрөг хуваарилахаас төрийн далбааны 40.0 мянга нийт 4,160.0 мянган төгрөгийг аймгийн СХ-ны данснаас шилжүүлсэн.
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх ачаа, томилолтын зардал	52,628.00	18,220.00	34,408.00	Сумдын хэсгийн хороонд томилолтын зардал 18,220,000₮ (104 хэсгийн тоо*170,000₮) унааны зардал 5,600,000₮(20сум*400км*700₮), Аймгийн сонгуулийн хороонд саналын хуудас, санал тоолох төхөөрөмж, дагалдах хэрэгслийг СЕХ-оос авах, хүргэж өгөх, сумд хэсгийн хороонд хүргэж өгөх зардалд 52,628,000₮ төгрөг хуваарилсан байна.



10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.00		1,300.00	Аймгийн сонгуулийн хороонд 1,300,00₮ -ийг хувиарласан байна.
11	Сонгуулийн хорооны гишүүний гишүүдийн урамшуулал, НДШ	669,592.00	662,816.00	6,776.00	Сумын сонгуулийн хорооны 140 гишүүн, сумдын 104 хэсгийн 936 гишүүн, аймгийн хэсгийн хорооны 10 гишүүнд 550,000₮-ийн урамшуулал, 66,000₮-ийн НДШ-ийн зардалд 668,976,000₮ хуваариласан байна. (140 хүн*616000+936хүн*616000+10*616000)
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	80,696.00	77,616.00	3,080.00	Сумын хэсгийн хорооны 104 даамал, аймгийн хэсгийн хорооны 5 даамал, сумдын хэсгийн хорооны нөөц 22 даамалд 550,000₮-ийн урамшуулал, 66,000₮-ийн НДШ-ийн зардалд 80,696,000 хуваариласан байна. (104 хүн*616000+5хүн*616000+22*616000)
13	Хоолны зардал	60,900.00	60,100.00	800.00	Сумын сонгуулийн хорооны 140 гишүүн, сумдын 104 хэсгийн 936 гишүүн, аймгийн хэсгийн хорооны 10 гишүүн, Сумын хэсгийн хорооны 104 даамал, аймгийн хэсгийн хорооны 5 даамал, сумдын хэсгийн хорооны нөөц 22 даамалд 50000 төгрөгөөр тооцож 60,900,000₮-ийг хуваариласан байна. (140+936+10+104+5+22)*50000
14	Томилолтын зардал	13,876.00	11,780.00	2,096.00	Аймгийн Сонгуулийн хорооны томилолтын зардалд 2,096,000₮ (3хүн *2 удаа *200,000₮+1280 км *700₮) сумдын сонгуулийн хороонд 11,780,000₮ (2 хүн*170,000₮+400км*700₮)
15	Шуурхай багийн зардал	2,130.00		2,130.00	Аймгийн сонгуулийн хороонд хуваариласан байна.
16	Болзошгүй зардал	9,984.00		9,984.00	Аймгийн сонгуулийн хороонд хуваариласан байна.
Нийт		1,088,397.00	999,410.00	88,987.00	

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарь

Сумдын сонгуулийн хорооны хэсгийн хороо, даамлын сургалтын хоолны зардал, байр тохижуулах зардлаас бусад зардлыг СЕХ-ноос ирүүлсэн удирдамжийн дагуу хуваарилсан байна.

1.1.3 Аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс Монгол улсын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийн зарцуулалтын удирдамжийг мөрдөж ажилласан байна.

Монгол УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Улсын хэлтэст 102,997.1 мянга, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 36,586.0 мянган төгрөгийг хуваарилсан байна

Хүснэгт № 3. Зарим төрийн захиргааны байгууллагуудад хуваарилсан төсөв /мянган төгрөг/

Зардлын төрөл	Цалин шуурхай баг	Бичиг хэрэг	Тээвэр шатахуун	Дотоод албан томилолт	Бараа үйлчилгээний бусад зардал	Хичээл практик	шуудан холбоо	Хоол хүнс	Нийт дүн
1	Аймгийн Цагдаагийн газар	68,412.5	4,134.6	6,926.0	16,624.0	4,800.0	2,100.0		102,997.1
2	Аймгийн УБХ			2,000.0			10,130.0	24,456.0	36,586.0
Нийт дүн	68,412.5	4,134.6	8,926.0	16,624.0	4,800.0	2,100.0	10,130.0	24,456.0	139,583.1

Эх сурвалж: УБЕГ, ЦЕГ-аас ирүүлсэн албан бичиг

Дээрх төсвийг дээд газраас ирүүлсэн удирдамжийн дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст зарцуулалтын эрхийн хүсэлтийг хүргүүлэн зарцуулах эрхийг нээлгэсэн байна.



Бүлэг 1.2 УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?

Сонгуулийн хороодын зардлын зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зарим сонгуулийн хороо нь төсвийг зарцуулахдаа холбогдох журмын шаардлагыг бүрэн мөрдөөгүй байна.

1.2.1. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны а/17 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг зарим сумын сонгуулийн хороод нь мөрдөж ажиллаагүй байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Баянхонгор аймгийн сонгуулийн хороонд 1,088,397.0 мянган төгрөг хуваарилсныг гүйцэтгэлээр 1,082,540.0 мянган төгрөгийг зарцуулж 5,857.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитаар сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Баян-овоо, Бууцагаан сумд Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.1¹, 3.2² дахь заалтуудыг зөрчиж нийт 444.3 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн бусад зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

Сум	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал НДШ	Унааны зардал	сурталчилгааны зардал	Бичиг хэргийн зардал	МТД, даамлын сургалт	Санал авах байр бэлтгэх	Саналын хуудас, төхөөрөмжийг авах, хүргэх ачаа, томилолтын зардал
Баян-Овоо		30.0	0.7	(44.7)	14.1		
Бууцагаан	399.6	(2.8)		(129.6)	(7.2)	(130.0)	(130.0)
НИЙТ	399.6	27.2	0.7	(174.3)	6.9	(130.0)	(130.0)

Иймд дээрх хуваарилагдсан төсвөөс илүү зарцуулсан 444.2 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоож аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

- Шинэжинст сумын сонгуулийн хороо 115.8 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7³ дахь заалтыг зөрчсөн байгаа тул холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоож аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.
- Эрдэнэцогт сумын сонгуулийн хороо, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулалыг тооцож олгохдоо ХАОАТ-ыг 339.4 мянган төгрөгийг дутуу тооцоолж багийн гишүүдэд илүү олгосон байна.
- Гурванбулаг сумын сонгуулийн хороо нь сонгуулийн хороо, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулалын НДШ-ийг хэрхэн тооцох төлөх талаар 2024.05.29-ны өдрийн 04/1116 дугаар албан бичигт даатгуулагчаас төлөх НДШ 11.3 хувиар төлөхөөр байхад 11.5 хувиар төлж 52.8 мянган төгрөгийг илүү төлсөн байна.
- Баянбулаг сумын сонгуулийн хороо, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулалыг тооцож олгохдоо ХАОАТ-ыг 961.4 мянган төгрөгийг дутуу тооцоолж багийн гишүүдэд илүү олгосон байна.

Дээрх ХАОАТ, НДШ-ийг буруу тооцоолж олгосон буруутай албан тушаалтанаар төлүүлэх төлбөрийн актыг тогтоож аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

² Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

³ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.



- Жинст сумын сонгуулийн хороо нь мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулалаас тооцсон ХАОАТ-ын 3,190.0 мянган төгрөгийн Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын хэлтэс рүү шилжүүлсэн тул алдаа зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.

Аудитаар байр бэлтгэх зардлаас нийт хөрөнгийн чанартай 3,143.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн бөгөөд тухайн хөрөнгийг НББ-д бүртгээгүй байгаа тул дээрх хөрөнгийг харьяа орон нутгийн байгууллагад орлогод авхуулах албан шаардлагыг Аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 36,586.0 мянган төгрөг аймгийн Цагдаагийн газарт хуваарилагдаж ирж гүйцэтгэлээр 36,586.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Улсын хэлтэст 102,997.1 мянган төгрөг батлагдаж ирсэн бөгөөд 99,688.9 мянган төгрөгийг зарцуулж 3,308.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгогчийн нэрсийн жагсаалтай 104 хэсгийн хорооны 114 ширхэг компьютер, принтерийн тээвэрлэхээр иргэнтэй ачаа тээврийн гэрээ байгуулан мөнгийг шилжүүлэхдээ Э баримт шивүүлээгүй, ХХОАТ-ыг суутган тооцоогүй байсан бөгөөд аудитын явцад тухайн иргэнээр цахим төлбөрийн баримтын системд нөхөн шивүүлсэн.

1.2.2. Гурван сумын сонгуулийн хороо зардлын тайланг зөрүүтэй 2,701.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Сумдын сонгуулийн хорооны тайланг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 3 дугаар хавсралт маягтын дагуу тайланг гаргаж ирүүлснийг аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч хүлээж авсан байна.

Сумдын ирүүлсэн зардлын тайланг анхан шатны баримтаас тулган шалгахад Гурванбулаг, Бөмбөгөр, Баян-Өндөр сумд нийт 2,701.0 мянган төгрөгөөр тайланг зөрүүтэй гаргаж ирүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁴ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд тайланг зөрүүтэй гаргаж ирүүлсэн сумдын тайланг анхан шатны баримтын дагуу дахин гаргуулж аудитын явцад сонгуулийн зардлын тайланг залруулав.

Хүснэгт №4 Сумдын сонгуулийн зардлын тайлан залруулсан жагсаалт /мянган төг/

Сонгуулийн хорооны нэр	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Сонгуулийн дүн, баримт бичгийг хүлээлэгэн өгөх унаа, томилолтын зардал	НИЙТ
Гурванбулаг	(104.0)	450.0	1,100.0		1,446.0
Бөмбөгөр				620.0	620.0
Баян-Өндөр			635.0		635.0
НИЙТ	(104.0)	450.0	1,735.0	620.0	2,701.0

Эх сурвалж: Сумдын сонгуулийн зардлын тайлан

Аудитын илрүүлэлт:

- Баянлиг сумын сонгуулийн хороо нь 48,838.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 48,838.0 мянган төгрөгийг зарцуулсан ба сонгуулийн хороонд зардлын тайланг батлагаажуулж ирүүлээгүй байна.

⁴ "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"



- Баянбулаг сумын сонгуулийн хороо нь 39,983.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 39,983.0 мянган төгрөгийг зарцуулсан ба сонгуулийн хороонд зардлын тайланг батлагаажуулж ирүүлээгүй байна.

Аудитын явцад санхүүгийн тайланг нөхөн гаргуулж аудитын явцад залруулсан.

Сумдын сонгуулийн хороод нь тайлан ирүүлэхдээ тайлангийн товч танилцуулга, тодруулгыг ирүүлээгүй байхад аймгийн Сонгуулийн хороо хүлээж авч байгаа нь Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.3.2⁵ дахь заалтыг зөрчсөн байгаа тул зөрчлийг аудитын явцад залруулсан.

1.2.3. Аймгийн Сонгуулийн хорооноос зарим сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4 дэх заалтын дагуу СЕХ нь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад, аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавих чиг үүрэгтэй байгаа ба аймгийн сонгуулийн нягтлан бодогч нь сумдын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримтыг аймгаас хуваарилсан зардлын нэгтгэлтэй тулган зөрүүтэй гаргасан тайланг тухай бүр нь засуулах зэргээр хүлээж авахдаа хяналт хэрэгжүүлсэн гэх тайлбарыг өгсөн ч аудитаар зарим сумдын тайлан зөрүүтэй, анхан шатны баримт дутуу, хуваарилсан зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан байгаа нь хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Иймд аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг хүлээж авахдаа хяналтыг бүрэн хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байхыг аймгийн сонгуулийн хорооны даргад зөвлөв.

Аудитаар нийт 10,947.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 1,913.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 6,333.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 2,701.0 мянган төгрөгийн 5 алдааг сонгуулийн зардлын тайланд залруулсан.

_____оОо_____

⁵ Тайлангийн товч танилцуулга, тодруулга



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сонгуулийн ерөнхий хороо нь Баянхонгор аймагт УИХ-ын сонгуулийг зохион байгуулах улсын төсвөөс олгох зардлыг шаардлагатай мэдээллийг үндэслэн төлөвлөж, 1,088,397.0 мянган төгрөг хуваарилсан байна.
2. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг таван сумын сонгуулийн хороо мөрдөж ажиллаагүй байна.
3. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

_____оОо_____



ХАВСРАЛТУУД:

Хавсралтын нэр	Хуудасны тоо
УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, сонгуулийн хорооны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	1 хуудас
Баянхонгор аймагт УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгтгэл	1 хуудас
УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан сонгуулийн хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа	1 хуудас
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт	3 хуудас



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 146/140570 240/ ГНАГ-2024-
-06-УТА-ГА

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МҮЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Баян-Овоо сумын сонгуулийн хороо нь бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвөөс 44,700 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
2. Шинэжинст сумын сонгуулийн хороо нь анхан шатны баримтгүй 115,800 төгрөгийн анхан баримтгүй гүйлгээ хийсэн.
3. Бууцагаан сумын сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал НДШ-ийн зардлаас 399,600 төгрөгийг дутуу зарцуулж бусад зардлуудад гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.2 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна”, 3.8 дахь “Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн

005350600

байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5 “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчиж зарцуулсан 560,100 (Таван зуун жаран мянга нэг зуу) төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Энхжаргал, нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Н.БҮНЧИНСҮРЭН

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 147/НО 570 240 /ТНАГ-2024-
- 06-УТА-ГА

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Эрдэнэцогт сумын сонгуулийн хороо, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшууллыг тооцож олгохдоо ХАОАТ-ыг 339,400 төгрөгийг дутуу тооцоолж төсөвт төвлөрүүлээгүй.
2. Баянбулаг сумын сонгуулийн хороо, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшууллыг тооцож олгохдоо ХАОАТ-ыг 961,400 төгрөгийг дутуу тооцоолж төсөвт төвлөрүүлээгүй.
3. Гурванбулаг сумын сонгуулийн хороо нь сонгуулийн хэсгийн хороонд ажиллаж байгаа даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцохдоо даатгуулагчаас 52,800 төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хувь хүний орлогын албан татварын хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна.”, Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 3.2-т “бүх шатны сонгуулийн хэсэг, хороонд ажиллахаар томилогдсон Монгол Улсын иргэн”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”, 21 дүгээр зүйлийн 21.9 дэх “Энэ хуулийн 7.3.1, 7.3.2-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, урамшууллаас даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн

005050380

хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч нийгмийн даатгалын санд төлнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 дахь "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.4 дэх "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй", 4.2.3.5 дахь "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчиж зөрүүтэй тооцож төсөвт төвлөрүүлээгүй 1,300,800(Нэг сая гурван зуун мянга), илүү суутгасан 52,800(Тавин хоёр мянга найман зуу) нийт 1,353,600 (Нэг сая гурван зуун тавин гурван мянга зургаан зуу) төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Энхжаргал, нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Н.БҮНЧИНСҮРЭН

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 343/10570240/ГНАГ-2024
- 06-УТА-ГА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жинст сумын сонгуулийн хороо нь сонгууль, хэсгийн хорооны гишүүдийн урамшууллаас тооцсон ХАОАТ-ын 3,190,000 төгрөгийг Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс рүү шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчигдсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5041040

1. Буруу шилжүүлсэн 3,190,000 (Гурван сая нэг зуун мянга) төгрөгийг залруулж Баянхонгор аймгийн Татварын газрын хувь хүний орлогын татварын холбогдох данс руу шилжүүлж зөрчлийг арилгах

2. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Энхжаргал, нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Б.МӨНХБАТ

Н.БҮНЧИНСҮРЭН

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 342/А0570240/ГНАГ-2024
- 06-ШТА-ГА Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МҮЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойрогт улсын төсвөөс санхүүжүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймаг, сумдын сонгуулийн хорооны байр тохижуулах зардлаас дараагийн үйл ажиллагаанд ашиглах 3,143,000 төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл авсан байхад төсөвт байгууллагын бараа материалд шилжүүлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалт зөрчигдсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймаг, сумдын сонгуулийн хорооны байр тохижуулах зардлаас дараагийн үйл ажиллагаанд ашиглаж болох 3,143,000 (Гурван сая нэг зуун дөчин

5041036

гурван мянга) төгрөгийн бараа материалыг аймаг, сумын ИТХ-ын эргэлтийн хөрөнгөнд бүртгэх.

1. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Энхжаргал, нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Н.БҮНЧИНСҮРЭН

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно